

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|       |                                                                                                               |    |
|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1     | Аудитын гэрчилгээ .....                                                                                       | 2  |
| 2     | Аудитын тайлан .....                                                                                          | 4  |
| 2.1   | Оршил .....                                                                                                   | 4  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                         | 4  |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                        | 5  |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....                                              | 5  |
| 2.5   | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6  |
| 2.6   | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....                                         | 7  |
| 2.7   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....                                                    | 7  |
| 2.8   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....                                                   | 7  |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....                                   | 8  |
| 2.9   | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | 8  |
| 2.10  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                                                         | 8  |
| 2.11  | Шилэн дансны мэдээлэл .....                                                                                   | 9  |
| 2.12  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....                                                | 9  |
| 2.13  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....                                                                       | 9  |
| 3     | Менежментийн захидал .....                                                                                    | 10 |
| 4     | Аудит хийсэн санхүүгийн тайлан .....                                                                          | 12 |
| 4.1   | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                                                                  | 12 |
| 4.2   | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                                                               | 13 |
| 4.3   | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                                                   | 14 |
| 4.4   | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....                                                    | 16 |
| 4.5   | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                                                                | 16 |

## Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт            |
| АОУС     | Аудитын олон улсын стандарт                                 |
| ОБЕГ     | Онцгой байдлын ерөнхий газар                                |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН НӨӨЦИЙН “ОБЪЕКТ 03”  
САЛБАРЫН ДАРГА, ХОШУУЧ  
Б.ГАНБАТ ТАНАА

2019.02.25 № 06/218  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын нөөцийн “Объект 03” салбарын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын нөөцийн “Объект 03” салбарын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын нөөцийн “Объект 03” салбарын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Улсын нөөцийн "Объект-03" салбарын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг салбарын дарга, хошууч Б.Ганбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын нөөцийн "Объект-03" салбарын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын нөөцийн "Объект-3" салбар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

ОБЕГ-ын харьяа Улсын нөөцийн "Объект-3" салбар нь Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх замаар Монгол хүний аюулгүй амьдрах таатай нөхцлийг бүрдүүлж улс орны нийгэм, эдийн засгийн тогвортой хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Улсын нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлд Улсын нөөцийн салбарын үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- нөөцийн бараа, материалыг тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд нь зохих технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах;
- онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх, тээвэрлэж хүргэх үйл ажиллагааг эрхлэх;

- нөөцийн бараа, материалын үлдэгдэл, зарцуулалтын мэдээ, санхүүжилтийн тайланг сар, улирлаар гаргаж, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах;
- нөөцийн бараа, материалыг зарцуулах, бүрдүүлэхийн өмнө болон хадгалалтын явцад жилд 1-2 удаа чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг гаргуулж, холбогдох арга хэмжээ авах;
- нөөцийн бараа, материалыг хадгалах барилга, байгууламж, агуулахын нөхцөл байдалд чанар, стандарт, эрүүл ахуй болон ургамал хорио цээрийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулсан байх.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Улсын нөөцийн тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн

технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын нөөцийн "Объект-3" салбар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Улсын нөөцийн "Объект-03" салбарын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт орлогын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь гүйцэтгэлийн үе шатанд үйл ажиллагааны бус зардлын дүн хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалан эрс өсч нийт зардал нь бодитой бус илэрхийлэгдсэнтэй холбоотой юм.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын 2018 оны нийт орлого 514,088.1 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 10,281.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж тооцсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| (мянган төгрөгөөр) |               |     |       |         |
|--------------------|---------------|-----|-------|---------|
| №                  | Шийдэл        | Тоо | Дүн   | Тайлбар |
| 1                  | Зөвлөмж өгсөн | 2   | 660.8 |         |
|                    | Дүн           | 2   | 660.8 |         |

#### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

##### 2.8.1.1 Санхүүгийн тайлангийн залруулга

Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 7,824.1 мянган төгрөгийг цэвэр дүнгээр тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 7,824.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

#### 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад асуудал байхгүй.

#### 2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 487,896.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 487,090.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Улсын нөөцийн "Объект-3" салбар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийж ОБЕГ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улсын нөөцийн "Объект-03" салбарын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын нөөцийн "Объект-03" салбарын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын нөөцийн "Объект-03" салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

#### **3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэл**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Тайлант онд 98.9 мянган төгрөгийн НДШ-ийн авлага, 561.9 мянган төгрөгийн гэрэл цахилгааны зардлын өр төлбөртэй тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

#### **3.2 Цалин, нийгмийн даатгалын шитмгэлийн зардал**

### 3.2.1 Илрүүлэлт:

Батлагдсан төсөвт зохицуулалт хийж цалин, НДШ-ийн зардлын төсвийг тайлант хугацаанд 47,400.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч 7,824.1 мянган төгрөгөөр илүү тооцсон байна.

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “төсвийн зарчмыг мөрдлөг болгох” гэсэн төсвийн төслийг боловсруулах шаардлагатай нийцэхгүй байна.

### 3.2.2 Эрсдэл:

Цалингийн зардлын тооцоог зөрүүтэй хийж, санхүүгийн тайланд буруу илэрхийлэх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д төсвийн зарчмыг мөрдлөг болгох гэсэн шаардлагыг баримталж төсвийн төслийг боловсруулах

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт                  | Эхний үлдэгдэл                 | Эцсийн үлдэгдэл                |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>     | <b><u>73,056,451.63</u></b>    | <b><u>74,050,015.10</u></b>    |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>              | 00.00                          | 00.00                          |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                      | 894,221.00                     | 98,997.63                      |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                | 894,221.00                     | 98,997.63                      |
| 3351        | Байгууллагаас авах авлага          | 894,221.00                     | 98,997.63                      |
| 3352        | Хувь хүмүүсээс авах авлага         | 00.00                          | 00.00                          |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>              | 72,162,230.63                  | 73,951,017.47                  |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>          | 00.00                          | 00.00                          |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>         | 72,008,230.63                  | 73,870,017.47                  |
| 35410       | Бичиг хэргийн материал             | 525,250.00                     | 519,550.00                     |
| 35420       | Аж ахуйн материал                  | 54,118,557.28                  | 56,849,792.12                  |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл                    | 1,425,000.00                   | 1,208,500.00                   |
| 35440       | Түлш, шатах тослох материал        | 1,072,923.35                   | 535,775.35                     |
| 35450       | Барилгын засварын материал         | 83,500.00                      | 1,140,600.00                   |
| 35460       | Хүнсний материал                   | 00.00                          | 00.00                          |
| 35470       | Бусад хангамжийн материал          | 14,783,000.00                  | 13,615,800.00                  |
| 35500       | Биологийн хөрөнгө                  | 00.00                          | 00.00                          |
| 35600       | Мал амьтад                         | 154,000.00                     | 81,000.00                      |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b> | <b><u>4,526,233,528.75</u></b> | <b><u>7,657,808,054.38</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>              | 4,526,233,528.75               | 7,657,808,054.38               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                | 4,526,233,528.75               | 5,150,195,054.38               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц     | 4,886,761,690.68               | 4,936,701,950.19               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл              | -622,289,397.65                | -52,938,183.17                 |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл             | 163,310,680.00                 | 163,310,680.00                 |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл              | -77,396,096.52                 | -77,396,096.52                 |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)  | 82,483,719.96                  | 82,483,719.96                  |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл              | -75,181,099.08                 | -76,292,472.48                 |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил        | 71,192,851.79                  | 71,192,851.79                  |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл              | -69,519,170.43                 | -70,062,645.39                 |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө               | 5,396,250.00                   | 6,324,900.00                   |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл              | -5,396,250.00                  | 00.00                          |
| 39216       | Дуусаагүй барилга, байгууламж      | 166,870,350.00                 | 166,870,350.00                 |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>            | 00.00                          | 2,507,613,000.00               |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө             | 2,471,237.00                   | 2,510,084,237.00               |
| 39304       | Хуримтлагдсан элэгдэл              | -2,471,237.00                  | -2,471,237.00                  |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b> | <b><u>4,599,289,980.38</u></b> | <b><u>7,731,858,069.48</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>              | <b><u>00.00</u></b>            | <b><u>561,914.00</u></b>       |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>   | 00.00                          | 561,914.00                     |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                       | 00.00                          | 561,914.00                     |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                 | 00.00                          | 561,914.00                     |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг           | 00.00                          | 561,914.00                     |

Улсын нөөцийн "Объект 03" салбарын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|            |                                                                       |                         |                         |
|------------|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>4,599,289,980.38</b> | <b>7,731,296,155.48</b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 4,599,289,980.38        | 7,731,296,155.48        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан |                         |                         |
|            |                                                                       | 867,779,737.59          | 3,375,392,737.59        |
| 51101      | Өмч: - төрийн                                                         | 867,779,737.59          | 3,375,392,737.59        |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                                           | 3,543,171,271.92        | 2,362,178,320.91        |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                                    | 3,543,171,271.92        | 3,543,171,271.92        |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                                                  | 00.00                   | -1,180,992,951.01       |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 188,338,970.87          | 1,993,725,096.98        |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>4,599,289,980.38</b> | <b>7,731,858,069.48</b> |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

|             |                                                                                                            | /Төгрөгөөр/           |                       |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| Дансны код  | Үзүүлэлт                                                                                                   | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                                                     | <b>528,174,257.25</b> | <b>514,088,123.50</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                                                                 | <b>19,065,217.25</b>  | <b>19,173,023.50</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                                                         | 19,065,217.25         | 19,173,023.50         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                                                           | 19,065,217.25         | 19,173,023.50         |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                                                          | 19,065,217.25         | 19,173,023.50         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                                                       | <b>509,109,040.00</b> | <b>494,915,100.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                                                             | 487,631,200.00        | 487,496,100.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                                                          | 487,631,200.00        | 487,496,100.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                         | 21,477,840.00         | 7,419,000.00          |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,477,840.00         | 7,419,000.00          |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                                                         | <b>646,296,220.64</b> | <b>602,086,888.79</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                                       | <b>646,296,220.64</b> | <b>602,086,888.79</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                                                     | 630,896,220.64        | 593,262,765.79        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                                                   | 361,290,681.48        | 363,342,458.00        |
| 210101      | Үндсэн цалин                                                                                               | 272,698,122.00        | 240,560,069.00        |
